**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 04 өдөр Дугаар А/356 Мөрөн сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Шугаман эргүүл-Хар хэсэг” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад 3.000.000 (Гурван сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлын 3.000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6712011084

Захирамж2024